



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/245

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 43 дугаар зарлиг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архи согтууруулах ундааны хор уршгийг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх, донтох өвчнийг эмчлэх зорилготой нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээний хүрээнд Хэнтий аймагт Наркологийн төв байгуулах ажлын хэсэг Баянхонгор аймгийн Наркологийн төвд туршлага судлахад зориулж 2,964,000 (хоёр сая есөн зуун жаран дөрвөн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 04 өдрийн
А/245 дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр төрөл	Тоо хэмжээ / Нэгж (төгрөг)	Дүн
1	Шатхууны зардал	2 машин 700л	1,764,000
2	Томилолт	8 хүн 3 х* 50,000	1,200,000
Нийт			2,964,000